



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2019. 05. 01 № 14

Асуулга тавих тухай

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг Тост багт байрлах говь цөлийн бүсийн эмзэг экосистем, нэн ховор, ховор амьтад бүхий Тост, тосон бумбын нуруу орчмын нутаг дэвсгэрийг Улсын тусгай хамгаалалтад авч хилийн заагийг тогтоосон боловч "Сауд гоби коэл транс" ХХК-ийн эзэмшлийн MV-017038, MV-019036 дугаар тусгай зөвшөөрөл бүхий талбайнууд хамгаалалтын бүсэд оролгүй үлдсэн юм.

Тостын нуруунд усан хагалбар зэргэлдээх уул хоорондын хөндийн газар доорх усны тэжээлийн гадаад муж давхцан оршдог. Иймээс энэ нуруунд бүрэлдэж байгаа урсац Хөвд орчмын булаг шанд, баян бүрдүүд цаашлаад Хуршуутын гол, Нарийн сухайт орчмын олон тооны худаг ус булаг шандыг тэжээж байдаг учир уул уурхайн ашиглалтын явцад хатаж ширгэх, устаж үгүй болох эрсдэл үүсээд байгаатай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас энэхүү ээдрээтэй асуудлыг шийдвэрлэх тал дээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар Өмнөговь аймгийн иргэдийг төлөөлсөн Улсын Их Хурлын гишүүний хувьд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуултыг тавьж байна.

1. "Сауд гоби коэл транс" ХХК-д MV-017038, MV-019036 тусгай зөвшөөрлүүдийг олгохдоо тухайн нутаг орны иргэдийн саналыг авсан эсэх талаар;
  - "Сауд гоби коэл транс" ХХК-д MV-017038, MV-019036 тусгай зөвшөөрлүүд нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль болон бусад хууль эрх зүйн хүрээнд олгогдсон эсэх талаар;
  - "Сауд гоби коэл транс" ХХК нь тусгай зөвшөөрөл эзэмших хугацаандаа Байгаль орчны нарийвчилсан менежментийн төлөвлөгөөг батлуулсан эсэх талаар;
2. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин ба хүний нийгэмд нөлөөллийг Монгол Улсын хууль, олон улсын байгаль орчин ба хүний эрхийн гэрээ конвенцийн эрх зүйн норм, стандартад нийцүүлж байгаа эсэхэд хяналт тавьж буй эсэх талаар; зөрчлийг арилгуулах арга хэмжээ, эрх нь хөндөгдсөн талуудын эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлж буй эсэх талаар;

000000060

3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.4 дэх заалтыг үндэслэн Байгаль орчны тэнцвэрт байдал, байгалийн унаган төрх, түүх, соёлын үнэт өвийг тогтвортой хадгалах, устах аюулд орсон амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол бүхий Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч, хилийн заагийг 889000 га хэмжээтэй байхаар Улсын Их Хурлын 35 дугаар тогтоолыг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан. Гэвч 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 91 дүгээр тогтоолоор Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг 743058 га болгон өөрчилсөн нь Улсын Их Хурлын 35 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж буй эсэх талаар;

Уул уурхайн нөлөөллөөс болж Алтайн нурууны урд цэг болох Тост, Тосон бумбын нурууны экосистемийн хэв шинж аюул эрсдэлд орж, ус, бэлчээр, ан амьтад биологийн олон янз байдал тэдгээрийн амьдрах орчинд өөрчлөлт гарч болзошгүй байдалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын гишүүний хувьд зөвшөөрөхгүй гэдгээ албан ёсоор илэрхийлж байна.

Иймд Монгол Улсын Засгийн газраас энэ асуудлаар бодит байдал болон түүнд авах арга хэмжээний талаарх мэдээллийг ард түмэндээ өгөх шаардлагатай байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

